

“*ünege* (ҮНЭГ), *úsún* (ҮС)” ХЭМЭЭХ ҮГИЙН ГАРАЛ

М.Базаррагчаа *

Толь бичигт “үс сайхан, зүс улаавтар, нохойн намын, хөхөөр өсөх нэгэн зүйл араатан” гэж тайлбарлаад “Үнэг үсэндээ, хүн үгэндээ үхнэ; Үнэг сүүлээрээ хууравч үйл лай төөргөөрөө ирдэг” гэсэн хэлц зэргэдийг ишилжээ.¹ Энэ хэлцэд “үс, сүүл” гэсэн хоёр үг нь үнэгний гол шинжийг заажээ.

Г.И.Рамстедт “үнэгэн чоно, үнэгэн бүргэд, үнэгэн шувуу” зэрэг холбоо үгийг дурдаж “*ünügen, ünigen*” (үнэг) гэхчлэн, “*ü~i*” эгшиг сэлгэсэн, хоёр хувилбарыг бичээд “*üniyē*” (үнээ) хэмээх үгтэй харьцуулан үзэхийг сануулжээ.² Н.Поппе “*ünügen*” (үнэг) хэмээх үгийн эртний хэлбэрийг “*rüneken*” (үнэг) гэж сэргээгээд, манж хэлнээ “*fünexē~füniyexē*” < **rünekei*, (арьс, сэвсгэр, үнэгний арьс, нэхий), якут хэлнээ “*ünügäs* < **ünekäč*” (нохой) гэж харьцуулсан байна.³ В.И.Цинциус “үс ноос”-ыг түнгүүс манж хэлнээ “*фүнәһә*” (үс ноос, ноолуур), *фун`әхәнгә* (үсэрхэг сэвсгэр, сэвсгэр, сөдөрхөг, үс) эртний монгол хэлнээ “*ünegen, ünügen, ünigen*”, якут хэлнээ “*ün`ekäč* (гөлөг, баавгай)”⁴ гэж хэлдгийг харьцуулжээ.

Тэрээр энэ үгсийг монгол хэлний “*úsún*” (үс), манж хэлний “*фусэрә-*” (үсээр хөвөөлөх) -тэй харьцуулж, манж хэлний “*фун`ә-хә*” (үс) гэсэн үгийг “*úsún*” (үс) гэсэн үгтэй “*-sün, -хә*” дагаврыг хам олны утгатай дагавар гэж үзжээ. Якут хэлнээ “амьтны хэд хэдэн арьсыг нийлүүлж оёсныг” “*Үнәкән*”, “гөлөг, залуу нохой”-г “*ҮнҮгәс*” гэдэг байна⁵.

Ш.Цэцэнцогт “*úsún*” (үс) хэмээх үгийн өмнө “*h*” гийгүүлэгчийг сэргээсэн ба Г.И.Рамстедт “*ünüge*” (үнэг) хэмээх үгийн өмнө мөн “*h*” гийгүүлэгчийг мөн сэргээн, “*hünüge*” (үнэг) болгож, манж хэлний “*funehen*” (урт үс, сэвгэр үс), *fun* (үс), монгол хэлний “*úsún*” (үс), “*húsún*<*” *hünsún* (үс) гэх мэтээр харьцуулсан байна.⁶ Тэгвэл энэ үг

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Хэл шинжлэлийн тэнхим

¹) Монгол хэлний тайлбар толь. Уб., 2011, 1329-р т.

²) G.J.Ramstedt. Kalmueckisches woerterbuch, Helsinki.1935, p.458b

³) N.Poppe. Vergleichende Grammatik der Altaischen Sprachen, Teil 1. I, Wiesbaden, 1960, p.70

⁴) В.И.Цинциус, Этимологии алтайских лексем с анлаутными глухими придыхательными смычными губно-губным “*n*” и заднеязычным “*k*”, “Алтайские этимологий”, Лгр., 1984, 61-62

⁵) О.Н.Бётлингк. О языке якутов. Новосибирск, 1989. стр.486

⁶) Г.И.Рамстедт Введение в алтайское языкознание. М., 1957, стр.190

дуншаан хэлнээ “usun”, баоань хэлнээ “suŋ”, дагуур хэлнээ “xusu”, шар югар хэлнээ “hesun”, монгол хэлнээ “fūzə” гэж хэлэгддэгийг С.А.Старостин тэмдэглээд, түнгүс-манж хэлнээ “pu:ŋe”, япон хэлнээ “punui” гэж хэлдэг энэ үгийн эртний хэлбэрийг “pūnu” (үс, өд) гэж сэргээжээ.⁷ Мөн Г.И.Рамстедт “ūsūn” (үс) хэмээх үгийг “hūnsūn” гэж сэргээгээд, манж хэлнээ “funəxe” гэж хэлдгийг хавсарсан байна. Ингэж Г. И.Рамстедт “ūnege” (үнэг), ūsū(n) (үс)⁸ гэсэн хоёр үгийг манж хэлний баримтаар нэг гаралтай хэмээн үзсэн байна.

В.М.Иллич-Свитыч “ūsūn” (үс) хэмээх үгийг урал хэлтэнд “puna”(үс, ноос, өд сөд) дравид хэлтэнд “pūta” (үс, ноос, ноолуур, жижиг өд сөд), алтайн хэлтэнд “puna” (үс, ноос, өд сөд) гэж харьцуулан, нэг гаралтай болно⁹ гэжээ. Цаашилбал “ungγasu” (унгас), “ungγadu” (унгад), pungγasun (нунгас), cf. ungγas- (унгасах-дөлгүй шатаж утаа гарах) хэмээх монгол үгийг манж зүгийн хэлний funγada- (өдлөх), funγaxan (зөөлөн өд, ноолуур), fungala (өд) зэрэг үгстэй гарал нэг хэмээн үзсэн байна.

Монгол хэлний “ungγaril” (унгарил- нарийн ноос), “ūngge” (үнгэх), “ūng” (үн-үйрмэг), “ūnesū” (үнс), “kūne/ūsū” (хүнс-хэсэглэн бэлтгэсэн идээ) үгс ч “ungγasu” (унгас) хэмээх үгтэй ч холбогдоно.

Түрэг хэлнээ “ūngge-” (үнгэх)-ийг “ōŋ-”(id.) “өнгө”-ийг манж хэлнээ “fundexun” (цайвгар, зэвхий) гэх ба арьс зэргийн гадрыг ōngge (өнгө), ōnggūr (өнгөр), kōnggur (хөнгөр- өнгөр) гэх нь “үс ноос”-той холбогдох мэт санагдана. Тэгвэл onγyи (онгох гандах, өнгө нь үхэх) улмаар anγya (ангах), čanγyи (цангах), onγyиn (онгон дэл, онгон сахиус) зэрэг үгс үүссэн нь Т.А.Бертагаевын үзсэнчлэн үгийн утгын хугарсан хувьсах (рефракционное изменение слов) болно. Т.А.Бертагаев “onγyиn, onγyи” (онгон онго) хэмээх үгийг “on” (он), onisuyа (оньсого), onisu (оньс), oni (онь хөтөл), onciyūi (онцгой), onci (оньч), onubci (оновч) зэрэг үгтэй гарлаараа нэг гэж үзээд onγyиn (онгон) хэмээх үг нь “анхдагч, эрхэм, нандин, ариун, эмнэг, эрх, танхи, шүтээн” гэх мэт утгатай “onγyиd” (онгод) гэвэл “хий хүчин сүг дүрс” гэсэн утгатай¹⁰ гэж тайлбарласан авч, энэхүү “onγyиn” хэмээх үг нь anγya- (ангах), anγyāyи (ангайх), onγyи- (онгох), onγyиyи- (онгойх), ōnggeyи – (өнгийх) зэрэг дүрслэх үг үүссэн нь “уг юм ус чийгээ гээж” хатсанаас ангайн сангайн “эвдэрснээс” үүсжээ. Ингэж “уул юм ус чийгээ алдатлаа удах” гэсэн утгаас “онгох”, улмаар онгосон юм хатаж хатуу болсон тул онгосон өнгө зүсээ хэвээр хадгалах гэснээс “онгон” (onγyиn), onγyи (онго) хэмээх үг үүсэж, дархалж сэтэрлэсэн мал (онго мал), “бөөгийн шүтээний элдэв хэрэгслийг хадгалах мухлаг сав”, унаган шинжээрээ удтал хадгалсан юм (онгон дэл, онгон үс, онгон сүнс, Чингисийн онгон) гэх мэт утга салаалж, онгод (onγyиd), орох, онгод дуудах, онгод шүтээн зэрэг үгс бас үүссэн байна. Иймд “хатсан чигээрээ хадгалагдах” гэсэн үндсэн бодит утгаас “уг юмыг хэвээр нь

⁷) С.А.Старостин Алтайская проблема и происхождение японского языка, М.,1991, стр.275

⁸) G.J.Ramstedt. Kalmueckisches woerterbuch Helsinki. 1935, p.460

⁹) В.М.Иллич-Свитыч. Опыт сравнения ностратических языков (семито хамитский, картвельский, индоевропейский, уральский, дравидийский, алтайский), Сравнительный словарь (p-q), М.,1984, стр.81-84

¹⁰) 10.Т.А.Бертагаев. К этимологии некоторых слов в монгольских языках. “Исследования по восточной филологии,” К семидесятилетию профессора Г.Д.Санжеев”, М.,1974, стр. 34-39

хадгалж нрхнмлэхийг онголох”, сэтгэлд нь шинэ санаа буюу анхдагч дүрс орж ирэхийг заасан, “онгод” “онгон” хэмээх үг бий болжээ. Энэхүү *ongyu* (онго–шүтээн), *ongyun* (онгон) хэмээх үгийн “о” нь “ö”-тэй сэлгэвэл “тухайн юмын гадаргуу дээгүүр гарах” гэсэн утгатай “*önggeyü*” өнгийх, “*öngge*” өнгө, “*önggere*” өнгөрөх, “*önggür*” өнгөр, *önggebči* (өнгөвч-тохмын тийрэг), “*önggeg*” өнгөг цөнгөг, *ongyuy* “*čongyuy*” (онгог цонгог, онгорхой цоорхой, тангаг), *angyay čangyay* (ангаг цангаг), *angyayu čangya* (ангах цангах) гэх мэт үгс бүтсэн нь эдгээр үгсийн эхэнд сэлгэмэл “s~q/k~č~t” гийгүүлэгч байсан ажээ.

Ш. Лувсанвандан гуай “*öngge*” (өнгө), *önggeyü* (өнгийх) хэмээх үгийг гарал нэгтэй гэж үзсэн¹¹ нь зөв болох нь дээрх жишээнээс ил байна. Иймээс *angya-* (ангах), *čangya-* (цангах), *sangya-* (сангах), *ongyu-* (онгох), *ongyu-* (онго), *öngge* (өнгө), *üngge-* (үнгэх), *ungyas-* (унгасах) *ungyari-* (унгарах) зэрэг үгс нь “*nousu*” (ноос), *ungyasu* (унгас) хэмээх үгтэй гарал нэг бөгөөд эдгээрийн “u, ü” -т үгс нь манж хэлний “*fūhexei*” үнэг хэмээх “*hūnsūn*” үс хэмээх үгтэй гарал нэг болох ба нөгөө талаас “*ürsūyi*” үрсийх “*bürsūyi*” (бүрсийх) гэсэн дүрслэх үгийн “r” гийгүүлэгч гээгдэн, “*üsūn*” үс хэмээх үг үүссэн байж болох юм. Ийнхүү “уул юмсын чийг ус хомстон хомстсоор хатаж”, ангайх сагсайх болж, түүнээс ангах, цангах, улмаар онгох гандсанаас “*ongyu, ongyu, öngge, önggere-*” зэрэг бий болсон нь Т.А.Бертагаеваас үгийн утга алгасан салаалан холдох хувьсал буюу хугарсан хувьсал (рефракционные изменения слов) болох ажээ.¹²

Энэ нь Г.И.Рамстедтын сэргээн босгосон *hūnsūn* (үс үнэг) хэмээх үгийн “n” нь гээгдвэл “*üsūn*”(үс), “n” нь арын эгшигтэйгээ байвал “*uneye*” үнэг хэмээх үг салаалжээ.

Монгол хэлний “*ungyasu*” гэдэг үгийн “ung” нь манж хэлний “*rūnexə*” гэдгийн “*run/e*”-тэй таарах ба “ya” нь оруулбар үе-утгалбар болох тул “*noisu~noyusu*” (ноос) хэмээх “ng” нь гээгдсэнээс үүсэлтэй “*noisa*” хэмээх үг бий болжээ.¹³ Алтайн хэлнүүдэд “*noqai*” (нохой) гэдэг нь “*fūhexə*” тай гарал нэг¹⁴ гэсэн нь ортой юм. Учир нь “*fūhexə*” гэдгийн “r” ба “ü” нь гээгдэж “*nexə*” гэж үлдсэнээс “*noqai*” хэмээх үг салаалсан байж болох юм.¹⁵ Мөн *fūnepen* (үнэг, үс) хэмээх үгийн “ne” нь “te”-тэй сэлгэх тул *barsāyi* (барсайх), *borsūyi-* (борсойх), *burāysi-* (бурсайх), *börsūyi-* (бөрсийх), *bürsūyi-* (бүрсийх), *sa~ta: bartāyi-* (бартайх), *bortūyi-* (буртайх), *börtūyi* (бөртих), *bürteyi* (бүртих) зэрэг дүрслэг үгсийн “ü”- т үг нь “*üsūn*” үс хэмээх үгтэй гарал нэг байж болно.

bürsūyi- (бүрийх) хэмээх үгийн “-sü” үе-утгалбар нь “*üsūn*” үс хэмээх үгийн эх үүсвэр байж болно.¹⁶ Эдгээр үгийн эхний “b” гээгдэж *arsāyi* (арсайх), *orsūyi* (орсойх),

¹¹⁾ Ш.Лувсанвандан. О некоторых корнях и основах в монгольском языке. Доклады монгольской делегации на XXVI конгрессе востоковедов. Уб., 1963, стр.9

Ш.Лувсанвандан. Орчин цагийн монгол хэлний бүтэц, Монгол хэлний үг нөхцөл хоёр, Уб.,1968,119-рт

¹²⁾ Т.А.Бертагаев. Лексика современных монгольских литературных языков, М.1974, стр.91-100

¹³⁾ М.Базаррагчаа. Монгол үгийн гарлыг мөшгөх нь, III-IV дэвтэр, Уб., 1995, 97, 306-р т.

¹⁴⁾ В.М.Иллич-Свитыч. Опыт сравнения ностратических языков (семито-хамитский, картвельский, индоевропейский, уральский, дравидийский, алтайский), Сравнительный словарь (p-q), М.,1984, стр.84

¹⁵⁾ М.Базаррагчаа Дээр дурдсан зохиол, 5-6, 49-52-р т.

¹⁶⁾ М.Базаррагчаа Дээр дурдсан зохиол, 314, 335-365-р т.

úrśúyūi-(үрсийх) зэрэг үүсэх ба үүний “úrśúyūi” гэсэн дүрслэх үг нь “ú-r-sú-n” гэж үүссэн ч байж болно. Нөгөө талаас Б.Ринчен авгай “únegen, únege” (үнэг) гэдэг нь “úne-” гэсэн язгууртай бөгөөд “únúr” (үнэр) гэсэн утгатай язгуураа залгагдан “оготно хулганын үнэр шиншлэн гүйдэг нэгэн араатны нэр болгосон “-ge” дагавар ...”¹⁷ хэмээн өгүүлжээ. Энэхүү “únúr” (үнэр) гэсэн үг нь “tanur” (үнэр танар), tani- (таних), (uig:tonu,tanida; tur.tanae ~ tani. (id), tanir (танир), anir (анир), tanuу (танаг-сураг, тар тамир, танаг тасрах), tangda- (тандах), tangna- (тагнах), čingna-(чагнах)¹⁸ зэрэг үгтэй гарал нэг бөгөөд “-ni~nu” гэсэн дэд үе утгалбар нь “-mi” үе- утгалбартай сэлгэж, tamiр (тамир-тэнхээ чадал, далд санаа-дотуур тамир) хэмээх үг үүсжээ. Эдгээр үгс нь tang tang ki (тан тан хийх), čing čing (чин чин хийх) гэсэн авиа дуурайх үгсээс үүсэж, “-ng” авиалбар нь “-m”-ээр сэлгэж, tam tam ki- (там там хийх) мөн “-ki” нь “si”-тэй сэлгэж, tamsi-(тамших), tamsiyā (тамшаа), tamsiyāla (тамшаалах) хэмээх үгс салаалсан байна. Үүнчлэн “anir” (анир), tanir (танир) хэмээх үгийн “-ni” үе- утгалбар нь “mi”-тэй сэлгэж, amiуā(амиа), ami(амь нас), čimegē (чимээ), čimegē amiуā (чимээ амиа), čimegē imegē (чимээ имээ) гэсэн үгс салаалсан нь “алив юмын дуу чимээ нь уг юмын дотоод чанараас шалтгаалах буюу дотоод чанараа илтгэх” үйлтэй холбогдоно. Тиймээс činar (чанар), čing (чин үнэн), čimúge (чөмөг) зэрэг үг дам дамаа үүссэн байна.¹⁹ Б.Ринчен авгай “činar” хэмээх үг нь угтаан эрт дээр цагт “tinar” байсан нь “ti-” нь “ci-” болж ирсэн байнам. Эртний тэр “tin” гэдэг язгуур нь одоо түрэг хэлтэнд байгаа нь, алтайн түрэг аман аялгуунаа “tin” гэж “сүнс сүлд” гэсэн утгатай үг²⁰ súnesú (сүнс) гэдгийн “sún-, tin~tin”-тэй холбогдолтой болох нь “t~s” сэлгэдэг ёс “i~ú” сэлгэдэг ёсоор “tin~tin~ sún~ súl” гэж “n~l” сэлгэдгийн зүй тогтлоор хувилбарлан гарч “tin+a+r, tin+a+r, sún+e+sú+n, súl+de-” гэх зэргээр дагаврын байдлаар баахан баахан өөр өнгө санаа нэмэн оруулсан болов уу гэж “činar” хэмээх үгийн талаар сонирхолтой чухал санаа дэвшүүлжээ. Энэ бүхнээс

манж: fúnexə~rúneken (үнэг)
 якут: ún`ekäč~únúgäs, únekäč (нохой)
 монгол: únege~únúgen~ únigen (үнэг)
 манж: fún`exə, fun (үс), pu:ne` (үс)
 якут: únúgäs (нохой), únúkän (арьс)
 монгол: húsún~ húnsún (үс)
 япон: rānai (үс)

гэж харьцуулбал, монгол хэлний “-ge” дагавар нь манж, якут хэлний “-ke~he” дагавартай гарал нэг бөгөөд гагцхүү “-ge~ke” гэсэн үе- утгалбарын сэлгэцээр үүссэн ажээ. Г.И.Рамстедт монгол хэлний “үс” хэмээх үгийг húsún (үс) гэж дундаа “n”-тэй сэргээсэн нь манж хэлний fun (үс), fúnexə (үс), якут хэлний únúkän (үс), япон хэлний rānai (үс) зэрэгтэй жишсэнээс үүдэлтэй байна. Энэ нь монгол хэлний unγasu (унгас), unγaril (унгарал) unγan (унаган (зөөлөн) зан), nungγasu (нунгас) зэрэг үгийн “nung” нь “fun”, “fanai” зэрэгтэй тохирох ба эхний “f” нь “n”-тэй сэлгэсэн байж болох бөгөөд хүн

¹⁷⁾ Б.Ринчен. Монгол бичгийн хэлний зүй. Дэд дэвтэр, Авиан зүй. Уб.,1966.141-рт.

¹⁸⁾ Ш.Цэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь, Жанг Жияа Кэү, 1988., 1764-1767-рт

¹⁹⁾ М.Базаррагчаа “činar, únúr, činayši, tani-, abiуā” зэрэг үгсийн гарал нэг болох нь “Сургалт-эрдэм шинжилгээний бичиг” №6, 2010, 4-9-рт.

²⁰⁾ Б.Ринчен. дурдсан зохиол, 343-р т. ; Б.Ринчен. Монгол бичгийн хэлний зүй. Дөтгөөр хэлний зүй, Дээд өгүүлбэр зүй. Уб.,1967. 3-6-рт.

амьтны биед ургах эвэрлэг нарийн ширхэг зүйл” гэсэн “*ūsún, hūnsún*” хэмээх үг нь “*bürsüyi-ürsüyi-*” гэсэн дүрс дуурайх үгээс “*г*” нь “*н*” –тэй сэлгэж үүссэн байж болно. Үүнд “*н*”-тэй нь “зөөлөн ноолорхог үс”, “*г*”-тэй (*hürsún-ūsún*(үс) нь “хатуувтар үс” гэсэн утгатай юм.

Монгол хэлнээ “*n/labsi*” (навших-лавших), “*n/lobsi*” (новш~ловш), *min/layā* (мянаа~мялаа), *mangn/lāi* (магнай~манлай), *men/lekēi* (мэнэхий~мэлхий), *n/luūqa* (нуух~луух) *kemn/lel* (хэмнэл~хэмлэл), *en/le* (энэ~энэ), *ibegen/l* (ивээх~ивээл), “*n/labči*” (навч~лавч)²¹, *al/ndaγū* (алдуу~андуу), *angn/la* (агнах~анлах), *emne/lig* (эмнэг~эмлэг), *quriml/na-* (хуримлах~хуримнах), *imn/le-* (имнэх~имлэх), *kin/lamji* (хянамж~хяламж), *inčid-n/lančid-*, (инчдэх~ нанчдах~ ланчдах), *man/lūr* (мануул~малуур), *mangn/luγ* (магнаг~манлаг), *nemn/le-* (нэмнэх~нэмлэх), *nidun/lun* (ноднин~нодлин), *nomn/la-* (номнох~номлох) *tangn/lāi* (тагнай~танлай), *tengn/le* (тэгнэх~тэнлэх), *titimn/le-* (титэмлэх~титэмнэх), *tulumn/la-* (туламнах~туламлах), *ulamn/la-* (уламнах~уламлах)²² *ar/lčiyūl/r* (арчуул~арчуур), *adquyāl/r* (атхаал~атхаар), *abuyāli~abāl/ri* (авааль~аваарь), *baraγār/lqa-* (бараархах~бараалхах), *bariyūr/l* (бариур~бариул), *gōrōmer/l* (гөрмөр~гөрмөл) *gūrbūl/rdeī* (гүрвэлдэй~гүрвэрдэй), *gōrbūl/reg* (гөрвөлөг~гөрвөрөг), *yer/ldeng* (ердэн~елдэн-хууран~мэхлэгч), *kerčimel/r* (хэрчмэл~хэрчмэр), *keregūr/l* (хэрээр~хэрүүл), *kūrkir/le-* (хүрхрэх~хүрхлэх), *kūrel~küler* (хүрэл~хүлэр), *manūl/r* (мануул~малуур), *urbumal/r* (урвамал~урвамар), *ōrūgēli/ri* (өрөөл~өрөөр), *ōrgeli/reg* (өргөлөн~өргөрөг), *serkir/le* (сэрхрэх~сэрхлэх), *serkir/legūn* (сэрхрүүн~сэрхлүүн), *seyīlūmer/l* (сийлмэр~сийлмэл), *siraγ/la-* (шаррах~шарлах), *siral/rqa-* (шараллах~шарархах), *sil/rbegūr* (шилбүүр~ширвүүр), *siremer/l* (ширмэр~ширмэл), *siryul/ra-* (шургалах~шургарах), *tarimal/r* (таримал~таримар) *tenemel/r* (тэнэмэл~тэнэмэр), *tumturi/la-*(тумтрах~тумтлах), *tursiyūr/l* (туршуур~туршуул) *čol/rgi-* (цолгих~ цоргих), *čucaγ/la-* (цуцлах~цуцрах), *čil/rme-*(чилмэх~чирмэх~ирмэх), *udaγal/rig* (удаалаг~удаагар), *udamar/l* (удмар~удмал), *ul/rbur-* (улбарах~урварах) *ugūl~ulūr~uguyūl* (уруул~улуур), *ūyir/le-* (үйрэх~үйлэх, үйрхий)²³ гэх мэтээр “*n~l*” “*l~r*” авиа сэлгэж, тухайн үгийн хувилбар бүтээх ба

de- $\left. \begin{matrix} g \\ r \\ l \\ n \end{matrix} \right\}$ de-yi; da- $\left. \begin{matrix} \gamma \\ r \\ l \\ n \end{matrix} \right\}$ dā-yi-; do- $\left. \begin{matrix} \gamma \\ r \\ l \\ n \end{matrix} \right\}$ dū-yi-; dō- $\left. \begin{matrix} g \\ r \\ n \end{matrix} \right\}$ dē-yi-;

²¹⁾ М.Базаррагчаа. Монгол хэлний авианы чөлөөт сэлгэцийн тухай. Уб., 1992, 45-46-р т.

²²⁾ G.J.Ramstedt. Kalmueckisches wörterbuch, Helsinki.1935, p.1-458

²³⁾ М.Базаррагчаа. Монгол хэлний “-су-н” дагавар ба “су-н” дагаварт үгийн гарал, I, Уб.,1996, 3-18-р т.

$$\text{da-} \left. \begin{array}{l} \text{ng} \\ \text{r} \\ \text{b} \end{array} \right\} \text{qā-yī}; \quad \text{de-} \left. \begin{array}{l} \text{ng} \\ \text{r} \\ \text{b} \\ \text{l} \end{array} \right\} \text{kē-yī}; \quad \text{do-ng-kū-yī}; \text{ du-ng-qū-yī-}; \text{ dü-ng-kü-yī-}$$

гэхчлэн хэлний үзүүрийн “n” нь “r” авиалбартай сэлгэж болно.

$$\text{ba} \left. \begin{array}{l} \text{g} \\ \text{r} \end{array} \right\} \text{sā-yī-}; \quad \text{bo} \left. \begin{array}{l} \text{g} \\ \text{r} \end{array} \right\} \text{sū-yī-}; \quad \text{bu} \left. \begin{array}{l} \text{g} \\ \text{r} \end{array} \right\} \text{sū-yī-}; \quad \text{be} \left. \begin{array}{l} \text{g} \\ \text{r} \end{array} \right\} \text{se-yī-}; \quad \text{bō/ü} \left. \begin{array}{l} \text{r} \end{array} \right\} \text{sū-yī-};$$

$$\text{qa} \left. \begin{array}{l} \text{b} \\ \text{γ} \\ \text{r} \end{array} \right\} \text{sā-yī-}; \quad \text{kō} \left. \begin{array}{l} \text{b} \\ \text{r} \end{array} \right\} \left. \begin{array}{l} \text{g} \\ \text{se-yī-}; \end{array} \right\} \text{sū-yī-}; \quad \text{ke} \left. \begin{array}{l} \text{g} \\ \text{r} \end{array} \right\} \text{se-yī-}; \quad \text{sa} \left. \begin{array}{l} \text{b} \\ \text{r} \end{array} \right\} \left. \begin{array}{l} \text{γ} \\ \text{g} \end{array} \right\} \text{sā-yī-}; \quad \text{se} \left. \begin{array}{l} \text{b} \\ \text{r} \end{array} \right\} \text{se-yī-};$$

өөр хоорондоо сэлгэж, “уг юмын дээш чигт хөдлөх” буюу “эвдрэх утга” үүсэх бөгөөд эхний гийгүүлэгч нь гээгдэж “aṡsāyi-” агсайх, “arsāyi-” арсайх, “amsāyi-” амсайх, “emseyi-” эмсийх, “oṡsūyi-” огсойх, “orsūyi-” орсойх, “ürsūyi-” үрсийх зэрэг дүрслэх үгс бүтнэ. Эдгээр үгийн “-sa~su” үе утгалбар нь нэр бүтээх “-su-n” дагавартай гарал нэг ба “a”-т, “sa” нь “салах сарних”, “su-” нь олноос нийлж бүтэх гэсэн утгатай юм.²⁴

Дээрх үгсээс “degde” (дэгдэх), “delde-” (дэлдэх), “dende” (дээсдэх), “darqa” (дарх), “delke” (дэлхэх), “baṡsa” (барс), “borsu” (борсох –морь мал цуцах), “buṡsa” (бугсах-уурлах бухимдах), “bersegü(ü)” (бэрсүү), “qabsāi” (хавсай боов), “kōgse” (хөгсөх-хөөрөх уурлах), “ōgsü” (өгсөх), “kōbsürgen” (хөвсөргөн хөөрүү), “kerseü” (хэрсүү хянамгай-хашир), “saṡsaṡü” (сагсуу), “sabsa-” (савсах-навсах, баагих) зэрэг үг салаалжээ.

Ийнхүү хоёр үе утгалбарын завсар орсон хэлний үзүүрийн “l, r, n” уруулын “b~m” хамрын “m~n~ng” болон хэлний үзүүр хойгуурх “r~g” гийгүүлэгч сэлгэх ажээ. Эхний үе- утгалбараас алгасан орсон “-sa,-su” үе утгалбар нь “-ta,-ča...” үе утгалбартай сэлгэж, “baṡsaṡyi-”-аас баṡца, boṡsuyi-аас боṡца/u, boṡtu-s /богт/с (чөмөг), “begseyi-”ээс begče-yi (бэгцийх), bögcüyi- (бөгцийх), bögtüyi- (бөгтийх), bögtürge (бөгтрөг), baṡtara- (багтрах), begtere-(бэгтрэх -тэвдэх), begter (бэгтэр- дотор ялтсан хуяг), baṡtara-(багтрах-нэвт хатгах, лав угларах) baṡta-(багтах) зэрэг үг үүссэн байна. баṡta- (багтах), баṡца-(багцах), baṡtara-(угларах) зэрэг нь “тухайн юм бөөгнөрөх” буюу “нэг нь нөгөөдөө багтах угларах” гэсэн утгатай тул “e”-гээр сэлгэсэн “begter” бэгтэр “дайсны сумнаас халхлах

²⁴⁾ М.Базаррагчаа. Монгол хэлний “су-н” дагавар, ба “-сун” дагаварт үгийн гарал. I. Уб., 1996,3-18-р тал., Монгол хэлний авиа сэлгэх ёс, Уб., 1987, 169-р тал.

ялтсан хуяг” хэмээх үг нь “нэг нь нөгөөгийн дор угларч бүтсэн хуяг” гэсэн утгатай ажээ.

РЕЗЮМЕ

На основе происхождения слова “fūnehэ” (шкура, пушистый, лисья шкура, овчина) в маньчжурском языке, некоторые монголоведы как Г.И.Рамстедт и Н.Н.Поппе рассматривали слова “ūnege”(лиса) “ūsūn”(волосы) из одного генезиса. Тем самым они реконструировали начальную форму слова “ūsūn” в результате чего образовалось “hūnsūn” (волосы) в древнемонгольском языке. По мнению автора следующие слова “ūnege” (лиса), “ūsūn”(волосы), “ūngge” (разминать), “ungyasu”(шерсть), “ungyan”(мягкий) одинаковы по происхождению и вторая силла-семема “-ne/i” этих слов может чередоваться с силла-селимами “-ga/i” в словах “būrsūyi-” (торчать), ūrsūyi- (торчать).

И так семантическую филиацию этих слов можно назвать рефракционными изменениями.